

## МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо /цаашид Холбоо гэх/-ны гишүүнчлэлийн журмын зорилго нь “Төрийн бус байгууллагын тухай”, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль болон Холбооны дүрмийн хүрээнд энэхүү журмын 1.3-д заасан этгээдүүдийг гишүүнээр элсүүлэх, түдгэлзүүлэх болон гишүүнээс хасахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журмыг Холбооны Их хурлаар хэлэлцэн батлах бөгөөд Холбооны нийт гишүүд дагаж мөрдөнө.
- 1.3 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1-24.1.3, 24.1.5, 24.1.9, 24.1.11, 24.1.13-д заасан үйл ажиллагааг эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдүүд Холбооны мэргэжлийн гишүүн, мөн тус хуулийн 24.1.4, 24.1.6-24.1.8, 24.1.10, 24.1.12, 24.1.14-24.1.17-д заасан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд болон Даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид, Арилжааны банкууд, Хувьцаат компаниуд, Хөдөө аж ахуйн брокерууд, Санхүү, эдийн засгийн чиглэлийн их дээд сургуулиуд нь Холбооны хамтрагч гишүүн байна.

### Хоёр. Холбооны гишүүнд тавигдах шаардлага

- 2.1 Гишүүнээр элсэх сонирхолтой этгээд дараах шаардлагыг хангасан байна:
  - 2.1.1 Сонирхогч этгээд нь энэхүү журмын 1.3-д заасан шаардлагыг хангасан байх
  - 2.1.2 Холбооны дүрэмтэй танилцаж үзэл баримтлал, үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрсөн байх
  - 2.1.3 Холбооноос гаргасан Мэргэжлийн ёс зүйн дүрэм болон Үнэт цаасны зах зээлийн зөвлөмжтэй танилцан дагаж мөрдөхөөр зөвшөөрсөн байх /Code of ethic, Code of conduct/

### Гурав. Холбооны гишүүнчлэл, гишүүнээр элсэх журам

- 3.1 Гишүүнээр элсэхийг хүссэн этгээд нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн Холбооны ажлын албанд хүргүүлнэ. Үүнд:
  - 3.1.1 Гишүүнээр элсэх өргөдөл /Хавсралт1/
  - 3.1.2 Мэргэжлийн байгууллагын хувьцаа эзэмшигч болон удирдах ажилтнуудын анкет
  - 3.1.3 СЗХ-оос авсан тусгай Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
  - 3.1.3 Мэргэжлийн байгууллагын танилцуулга
  - 3.1.4 Гишүүний элсэлтийн хураамж төлсөн баримт
- 3.3 Холбооны ажлын алба нь хүсэлтийг хүлээн авсанаас хойш 14 хоногийн дотор хянан бүрдэл гүйцэд тохиолдолд Холбооны Удирдах зөвлөлд хүргүүлнэ.
- 3.4 Гишүүнээр элсэх өргөдлийг Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар мэргэжлийн байгууллагын төлөөлөх эрх бүхий этгээдийг байлцуулан хэлэлцэх бөгөөд Удирдах зөвлөл нь тухайн этгээдийг гишүүнээр элсүүлэхээс татгалзах болон түр хугацаагаар түдгэлзэх эрх эдлэнэ.
- 3.5 Холбооны гишүүнээр элссэн мэргэжлийн байгууллагын удирдлага Удирдах зөвлөлийн гишүүдийн өмнө “Зах зээлийн нийтлэг эрх ашгийг хүндэтгэж, Холбооны дүрэм,

- журам, ёс зүйн хэм хэмжээ, шударга ёсыг чандлан мөрдөж ажиллахаа тангараглая.” хэмээн тангараг өргөж, Холбооны туганд ёслоно.
- 3.6 Холбооны Удирдах зөвлөлийн дарга хүсэлт гаргасан этгээдэд гишүүний гэрчилгээг гардуулан өгч, Гишүүнчлэлийн гэрээ /Хавсралт 2/-г байгуулснаар Холбооны гишүүн болно.
- 3.7 Шинээр элссэн гишүүний тухай мэдээллийг Холбоо өөрийн вэб хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.
- 3.8 Гишүүн нь холбоотой ижил төстэй зорилго, үйл ажиллагаа эрхлэгч үнэт цаасны зах зээлийн бусад мэргэжлийн байгууллагуудын холбоо, эвслийн гишүүнээр элсэхдээ Холбоонд мэдэгдэнэ.

### **Дөрөв. Гишүүний эрх, үүрэг**

- 4.1 Гишүүн нь үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын харилцагч нарт хөнгөн шуурхай үйлчилж, үнэт цаасны зах зээлийг улам өргөжүүлэхийн төлөө шамдан ажиллана.
- 4.2 Гишүүн байгууллагад ажиллаж буй мэргэжилтнүүд нь Холбооны дүрэм, журмууд болон үнэт цаасны зах зээлийн зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.
- 4.3 Гишүүн нь Холбооны дүрмийн 10.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараах эрхтэй байна:
- 4.3.1 Холбооноос зохион байгуулж буй сургалт, бусад арга хэмжээнд оролцох, төлбөрийн хөнгөлөлт эдлэх;
- 4.3.2 Мэргэжлийн чиглэлийн мэдээлэл авах;
- 4.3.3 Холбооны Их хуралд оролцох, Холбооны бодлого шийдвэр боловсруулах, хэлэлцэж, батлахад Холбооны дүрмийн дагуу саналын эрх эдлэх;
- 4.3.4 Гишүүнчлэлийн хураамжийн зарцуулалтын тайлантай танилцах, гаргуулж авах.
- 4.4 Гишүүн нь Холбооны дүрмийн 10.2 дугаар зүйлд зааснаас гадна дараах үүрэгтэй байна:
- 4.4.1 Холбооны дүрэм болон бодлогыг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцох, биелүүлэх;
- 4.4.2 Холбооны зорилго, зорилтыг дэмжин ажиллаж Холбооны нэр хүндийг гутаасан аливаа үйлдэл хийхээс зайлсхийнэ;
- 4.4.3 Холбооны дүрэм, мэргэжлийн ёс зүйн дүрэмд харшилсан үйл ажиллагаа явуулахгүй байх;
- 4.4.4 Холбооны бусад гишүүдийн нэр хүндэд харшлах аливаа үйлдэл хийхгүй байх.

### **Тав. Элсэлтийн хураамж болон гишүүнчлэлийн татвар**

- 5.1 Холбооны гишүүд нь Холбооны дүрмийн 11-р зүйлд заасан татварыг төлнө.
- 5.2 Гишүүний татварыг тухайн жилийн 1 дүгээр улиралд буюу 4 сарын 1-ний дотор төлсөн байна.
- 5.4 Хамтрагч гишүүн нь холбооны үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжлэг, туслалцаа үзүүлж болно.
- 5.5 Холбооны гишүүнээс сайн дураар эсвэл Удирдах зөвлөлийн шийдвэрээр Холбооны гишүүнээс хасагдсан тохиолдолд гишүүний хураамжийн талаар нэхэмжлэл гаргах эрхгүй.
- 5.6 Гишүүний хураамж, санхүүгийн дэмжлэг, туслалцаа нь тус холбооны үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулагдана.

### **Зургаа. Гишүүнд олгох шагнал урамшуулал**

- 6.1 Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан гишүүн байгууллагын мэргэжилтнүүдийн амжилтыг үнэлж төр засгийн шагналд тодорхойлно.

- 6.2 Холбооны тухайн жилд зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон идэвх, бодит хувь нэмэр оруулсан гишүүн байгууллага болон мэргэжилтэнд Холбооны шагнал урамшууллыг олгоно.

### **Долоо. Хариуцлага**

- 7.1 Холбооны гишүүн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Холбооны дүрэм болон энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Удирдах зөвлөлийн шийдвэрээр хариуцлага ногдуулна.
- 7.2 Гишүүнд ногдуулах хариуцлага нь сануулах, гишүүнээс түдгэлзүүлэх, гишүүнээс хасах гэсэн төрлүүдтэй байна.
- 7.3 Удирдах зөвлөл нь энэхүү журмын 7.2-д заасан хариуцлагын арга хэмжээг авахдаа гишүүний гаргасан зөрчлийн үр дагавар болон шаардлагатай тохиолдолд Холбооны Ёс зүйн хороо болон холбогдох бусад этгээдийн дүгнэлтийг үндэслэн ногдуулна.
- 7.4 Зөрчил гаргасан гэж үзэж буй Холбооны гишүүнд хариуцлага хүлээлгэхээс өмнө тухайн асуудлыг өөрт нь албан ёсоор танилцуулж тайлбар, хүсэлтийг авсан байна.
- 7.5 Удирдах зөвлөлийн бүх гишүүдэд тухайн тайлбар, хүсэлтийг хүргүүлж танилцуулсан байна.
- 7.6 Тухайн гишүүнтэй холбоотой зөрчил нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон тохиолдолд энэ талаар нийт гишүүдэд мэдэгдэнэ.

### **Найм. Гишүүнчлэлээс түдгэлзүүлэх, хасах болон гишүүнчлэлийг сэргээх**

- 8.1 Гишүүнээс сайн дураар татгалзахыг хүсвэл Холбооны ажлын албанд хүсэлтээ ирүүлнэ. Хүсэлтийг хүлээн авсны дараа нэг сарын дотор Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.
- 8.2 Дараах тохиолдолд Холбооны удирдах зөвлөл гишүүнд хугацаатай сануулга өгөх бөгөөд дээрх хугацаанд арга хэмжээ аваагүй тохиолдолд асуудлыг зохих ёсоор шийдвэрлүүлэхээр эрхийг 3 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ:
- 8.2.1 Гишүүн нь гишүүнчлэлийн хураамжийг 1 жил болон түүнээс дээш хугацаагаар төлөөгүй;
- 8.2.2 зах зээлийн нэр хүндийг унагасан үйл ажиллагаа явуулсан;
- 8.2.3 Холбооны дүрэм болон холбогдох бусад дүрэм, журамд харш үйл ажиллагаа явуулсан.
- 8.3 Дараах тохиолдолд Холбооны Удирдах зөвлөлийн шийдвэрээр холбооны гишүүнээс хасна.
- 8.3.1 Энэхүү журмын 8.2-д заасан арга хэмжээ авагдаж зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй;
- 8.3.2 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг ноцтой болон удаа дараа зөрчсөн нь тогтоогдсон;
- 8.3.3 Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхгүй болсон;
- 8.3.4 Гишүүн нь өөрөө хүсэлт гаргасан.
- 8.4 Энэхүү журмын 8.2, 8.3-д заасан арга хэмжээ авагдсан тохиолдолд Холбооны ажлын албанаас гишүүнд бичгээр мэдэгдэл хүргүүлнэ.
- 8.5 Энэхүү журмын 8.2-д заасан арга хэмжээ авагдсан гишүүн нь зөрчлийг арилгасан тохиолдолд энэ тухайгаа Холбоонд мэдэгдсэнээр Холбооны удирдах зөвлөл гишүүнчлэлийг сэргээх тухай шийдвэр гаргана.
- 8.6 Энэхүү журмын 8.3-д заасан арга хэмжээ авагдсан гишүүний тухай мэдэгдлийг Холбооны ажлын алба нь ажлын 3 хоногийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлнэ.

**“МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО”**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1-р хороо, Центр34 - 404 тоот  
Утас:7012-3339  
И-мэйл: info@masd.mn  
Вэб сайт: www.masd.mn

**ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ӨРГӨДӨЛ**

**Хуулийн этгээдийн нэр:** .....

**Хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл:** .....

**Хуулийн этгээдийн төрөл:** .....

ХХК:

100% гадаадын хөрөнгө оруулалттай, /Улс: . . . . . /

Дотоодын хөрөнгө оруулалттай

Хамтарсан, /Улс: . . . . . /

ХК:

**Хуулийн этгээдийн удирдлага:**

Хувьцаа эзэмшигчид: .....

.....  
.....  
.....  
.....  
.....

Гүйцэтгэх захирал: .....

Ажлын утас: .....

Гар утас: .....

И-мэйл: .....

**Хуулийн этгээдийн албан ёсны хаяг:**

Аймаг/хот: .....

Сум/дүүрэг: .....

Баг/хороо: .....

Гудамж/байшин/ хаалганы дугаар: .....

И-мэйл хаяг: .....

Вэб хуудас: .....

..... **ҮЦК нь Холбооны дүрмийг хүлээн зөвшөөрч, өөрийн  
сайн дураар тус холбооны гишүүн болохыг хүсч байгаагаа илэрхийлж, энэхүү хүсэлтийг  
гаргаж байна. Холбооны дүрэм, журамд заасан эрх, үүргийг сахиж ажиллана.**

**Өргөдөл гаргасан:**

Тамга . . . . . /

/Гарын үсэг/

/Нэр/

**Өргөдлийг бөглөж журмын 3.1-т заасан материалыг хавсаргана уу.**

## Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны Гишүүний гэрээ

20.. оны ... сарын . . . өдөр

№.....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монголын Үнэт цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо (цаашид “Холбоо” гэх)-г төлөөлж Ерөнхий нарийн бичгийн дарга . . . . . нөгөө талаас “Холбооны гишүүн” . . . . . ҮЦК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал . . . . . нар харилцан тохиролцож Холбооны дүрэмд заасан зорилго, үйл ажиллагааг дэмжих, гишүүнийхээ эрх, үүргийг чандлан биелүүлж ажиллахын баталгаа болгож байгуулав.

### Гэрээний зорилго

- 1.1 Холбооны дүрэм, дотоод журмуудыг сахин биелүүлж, гишүүдийн эрх, үүрэг, сахилга бат, нэгдмэл зохион байгуулалттай үйл ажиллагааг сайжруулж, Холбооны нэр хүндийг өндөрт өргөн, төр, олон нийтэд нөлөө бүхий төрийн бус байгууллага болгох явдал мөн.

### Холбооны эрх, үүрэг

- 2.1 Холбоо нь Төрийн бус байгууллагын тухай хууль болон Холбооны дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж, дотоод ардчилал, эрх тэгш, шударга харилцааг эрхэмлэж, гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах;
- 2.2 Холбооны гишүүдээс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу зохих арга хэмжээ авч, хариу мэдэгдэх.
- 2.3 Холбооны гишүүдийн нэгдмэл байр суурь, үзэл бодолд тулгуурлан Холбооны гадаад дотоодын албан харилцааг хөгжүүлэн гишүүдээ төлөөлөх;
- 2.4 Холбооны гишүүдийн хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүрэг болон Холбооноос гаргасан шийдвэрийг биелүүлэхийг шаардах;
- 2.5 Холбооны гишүүдийн нийтлэг эрх ашгийг ноцтой хохироосон үйлдэл хийсэн, Холбооны дүрэм, УЗ-ийн шийдвэрийг биелүүлээгүй гишүүдэд Ёс зүйн хорооны дүгнэлтийг үндэслэл болгон сануулах, торгох, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгуулахаар СЗХ-нд хандах, Холбооны гишүүнээс хасах арга хэмжээнүүдийг авах эрхтэй.

### Гишүүний эрх, үүрэг

- 3.1 Гишүүн байгууллагын төлөөлөл нь Холбооны бүх гишүүдийн хуралд оролцож Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, сонгогдох;
- 3.2 Гишүүн нь хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулж, Холбооноос дэмжлэг авах;
- 3.3 Гишүүн нь Холбооны үйл ажиллагааны талаар санал шүүмжлэл гаргах, холбогдох мэдээллийг гаргуулах эрхтэй.
- 3.4 Гишүүн нь Холбооны дүрэм болон ёс зүйн дүрэм, Холбооны удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагаас гаргасан тушаал, шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөх;
- 3.5 Гишүүн нь Хууль, дүрэм, журмын төслүүдэд санал өгөх, гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа болон Холбооноос зохион байгуулж буй аливаа арга хэмжээнүүдэд тогтмол идэвхтэй оролцох үүрэгтэй;

3.6 Гишүүн нь Холбооны дүрмийн 11-р зүйлд заасны дагуу Гишүүний татварыг Холбооны Их хурлаар тогтоосон хэмжээгээр жилдээ нэг удаа, Холбооны “Төрийн” банкны 100000206507 тоот дансанд тухайн жилийн эхний улиралд багтаан төлөх үүрэгтэй.

### Гэрээний хугацаа

4.1 Энэхүү гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

МҮЦАЭХолбоог төлөөлж:

Ерөнхий нарийн бичгийн дарга

.....

/ ..... /

И-мэйл: ceo@masd.mn

Утас: 70123339

Гишүүн байгууллагыг төлөөлж:

..... ҮЦК -ийн

Гүйцэтгэх захирал

.....

/ ..... /

И-мэйл:

Утас: